



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.04.25 № 1078  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г Дүгнэлт хүргүүлэх тухай 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд оролцох “Ард түмний олонхийн засаглал нам”-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тооцоо, судалгааг гаргаж, хуульд заасны дагуу хянуулан дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817:2020 стандарт, түүнийг хэрэгжүүлэх журам, заавар, аргачлалыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны Төсвийн төсөөллийн тухай хуулийг тус тус шалгуур болгож дүгнэлт гаргалаа.

**Дүгнэлт**

Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор “Ард түмний олонхийн засаглал нам”-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Ард түмний олонхийн засаглал нам”-ын мөрийн хөтөлбөр /...3...хуудас/-ийг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Z:\Yawsan\_Bichig\2024\0420 GNAG-3.Docx

0001030688

Ард Түмний Олонхийн Засаглал Намын  
2024 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн  
бага хурлаар батлав.



## “АРД ТҮМНИЙ ОЛОНХИЙН ЗАСАГЛАЛ” НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

“АРД ТҮМНИЙ ОЛОНХИЙН ЗАСАГЛАЛ” Нам нь Монгол Үндэстний Үндэсний язгуур эрх ашиг, нэгдэл, шашин шүтлэг, тусгаар тогтнол, уламжлалт төрийн хууль цааз, ёс суртахууны хэм хэмжээ, соёл, нийт монгол угсаатны зан заншлаа хадгалан хамгаалсан, хүчирхэгжүүлэн хөгжүүлэх үзэл санааг сууриа болгосон консерватив үзэл баримтлалтай нам юм.

### Нэг: Үндэсний үзэл санааны хувьсгал

- 1.1. Монгол Улс Монголын ард түмний язгуур эрх ашгийг хамгаас эрхэмлэн дээдэлнэ.
- 1.2. Уламжлалт хөрш ОХУ, БНХАУ болон гуравдагч хөрш улсуудтай найрамдалт харилцааг тууштай баримтлан хөгжүүлэнэ.
- 1.3. Иргэд, хүүхэд залуучууддаа эх орон, эх түүх, үндэсний хэл, бичиг, соёл уламжлалаараа бахархах дээдлэх ёс суртахууныг төлөвшүүлэх, үндэсний сэтгэлгээг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.4. Нийгмийн хөгжлийн хамгийн том саад болсон авлигын эсрэг, нийгэмд авлигыг, авлигачдыг үл тэвчих үзэл суртлын ажлыг явуулж өөрчлөх ажлыг үе шаттай өрнүүлнэ.
- 1.5. Хөдөлмөрч, бүтээлч хандлагыг иргэдэд төлөвшүүлж, хариуцлага, сахилга бат, дэг журам, хуульт ёс, хяналт бүхий боломжийг иргэддээ олгож бий болгоно.
- 1.6. Дэлхийн монгол угсаатнууд хэл, соёл уламжлалаараа нэгдэн нийтлэг болохыг дэмжинэ.
- 1.7. Боловсролын системд үндэсний түүх, хэл, соёл, уламжлалаараа хойч үеэ сурган хүмүүжүүлэхэд онцгой анхаарч бүх шатны сургуульд түүхийн хичээлийг оруулж шалгалт авдаг болгох, үндэсний боловсон хүчнийг хэрэгцээ шаардлагадаа тохирсон хэмжээнд бэлтгэх бодлого боловсруулна.

### Хоёр: Шударга ёсны хувьсгал

- 2.1. Сонгуулийн Ерөнхий Хороонд улс төрийн намууд, олон нийтийн байгууллага болон нам бус иргэдийн төлөөллийг оролцуулах, хяналт тавих хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх хууль санаачлана.
- 2.2. Сонгуулийн дүнг зөвхөн гараар тоолох хяналтын системийг дэмжих эрх зүйн орчныг бий болгоно.

00000001

2.3. Авлигатай нэр холбогдож, ял шийтгүүлсэн этгээдийн төрийн албанд ажиллах, сонгуульд оролцох эрхийг хязгаарлана.

2.4. Төрийн албан хаагчдыг мэргэжлийн салбарт ажиллуулахдаа дээрээс шууд томилдог босоо тогтолцоог өөрчилж, төр засгийн дунд, доод шатны байгууллагуудад ажил мэргэжил албан тушаал, ажилласан жил, туршлага, гавъяа зүтгэлийг нь харгалзан үзэж томилдог байсан итгэл үнэмшлийн зарчмыг сэргээнэ.

2.5. Бүх ард түмний нийтээр мөрдөх улс төрийн ёс зүйн хуулийг санаачлана. Хүний эрх, эрх чөлөөний асуудлыг онцгой анхаарч, зөрчигдөж буй нөхцөл шалтгааныг судлаж, хяналтын механизм, эрх зүйн орчныг бүрдүүлэхийн төлөө үйл ажиллагаа явуулна.

### Гурав: Аж үйлдвэржилт эдийн засгийн хувьсгал

3.1. Үндэсний эдийн засгийн тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бий болгохоор чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. Төр нь зах зээлээ хамгаалсан, төлөвлөгөөтэй үйлдвэржилтийг хөгжүүлсэн экспортлогч орон болгохыг дэмжинэ.

3.2. Бусад улс орнуудын түүхий эд бэлтгэн нийлүүлэгч болж баялгаа боловсруулалгүй экспортодог эдийн засгийн сул дорой тогтолцооноос улс орноо салган, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд анхаарал хандуулна.

3.3. Оюун ухаан мэдлэг, шинжлэх ухаанд суурилсан, технологийн дэвшилтэт шийдлийг дэмжиж хөгжүүлэгч, олон тулгуурт холимог эдийн засгийн бүтцийг бий болгож, үр өгөөжийг нь нийт иргэддээ тэгш хүртээдэг, баялаг бүтээгч иргэдэд эдийн засгийн тэгш боломж олгохыг дэмжинэ.

3.4. Төрийн албанд орон тоо нэмж ажлын байрыг бий болгохыг хязгаар тогтоож, жил бүр үйлдвэржилтийн бодлогын дагуу иргэдээ ажлын байраар хангах бодлогыг барина.

3.5. Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, инноваци цахим технологи, цэргийн орчин үеийн үйлдвэрлэлийн салбарыг тууштай хөгжүүлэхийг дэмжинэ.

3.6. Төсөв, санхүү, банкны бодлогод эрс өөрчлөлт хийж, төсвийн хөрөнгийн зарцуулалтыг ил тод нээлттэй болгоно. Төсвийн хэмнэлтийн бодлого барьж, өр зээлийн урхинд орох эрсдлээс хамгаалах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхийн төлөө ажиллана.

3.7. Засгийн газраас явуулж байгаа төсвийн бодлого, зарцуулалтанд иргэд хяналт тавих, үзэл бодол, гарц, гаргалгааг хэлэлцэх боломжийг судлаж дэмжинэ.



00000002

- 3.8. УИХ-аас татварын бодлогод сөргөөр нөлөөлөх эрх ашгийн зөрчилтэй хууль санаачлахын эсрэг бодлого баримтална. УИХ болон ЗГ-ын гишүүд хараат бус ажиллаж хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын хоорондын хамаарлыг арилгана.
- 3.9. Жижиг, дунд үйлдвэрүүдийг татварын бодлогоор болон хөнгөлөлттэй зээл тусламжийн бодлогоор дэмжиж, дотоодын зах зээлээ хамгаалах, үндэсний үйлдвэрлэгчид, баялаг бүтээгчдээ дэмжих эх оронч худалдан авалт хийх үйл ажиллагааг төрийн бодлогын түвшинд явуулах санаачлага гаргана.
- 3.10. Үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшийг чангаруулах, худалдан авах чадварыг сайжруулах бодлого барина.
- 3.11. Цалин тэтгэврийг инфляцийн түвшинд зохицуулан ханшыг барих бодлого барина.
- 3.12. Үндэсний эдийн засаг дахь стратегийн чухал ач холбогдолтой бүтээгдэхүүн болон объектуудад тавих төрийн хяналтыг сайжруулж, төрийн өмчийг үнэгүйдүүлсэн алдаа завхралыг арилгах хуулийг санаачилна.
- 3.13. Архи, согтууруулах ундаа, тамхи гэх мэт хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортод хяналтыг сайжруулж, өндөр татвар оногдуулах замаар хязгаарлана. Нийт иргэдийнхээ эрүүл мэнд, цус ойртолтын өвчний эсрэг бодлого боловсруулж хэрэгжүүлэнэ.
- 3.14. Үнэт цаасны зах зээлийн хөгжил дэвшлийг болон иргэд, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд чөлөөтэй оролцдог орчин үеийн системийг дэмжинэ.
- 3.15. Төвлөрөлийг сааруулах бодлогын хүрээнд залуучуудыг хөдөө орон нутагт очиж ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхийн тулд явуулж буй засгийн газрын бодлого шийдвэрүүдийг дэмжинэ.
- 3.16. Бэлчээрийн мал аж ахуйг хамгаалах, уул уурхайн бодлогыг зөв хөгжүүлэх талаар бодлого дэвшүүлж, малчдын хүсэл, санаачлагыг тусгаж дэмжих бодлогыг хэрэгжүүлж ажиллана.
- 3.17. Улсын Их Хурлаас баталсан улс орон даяар хэрэгжүүлэх “Алсын хараа - 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, шийдвэр болон Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан асуудлуудыг дэмжиж ажиллах болно.

**ИХ МОНГОЛ УЛСЫН ГАЛ ГОЛОМТ СҮР ХҮЧИЙГ ҮҮРДИЙН ҮҮРД,**

**ҮЕИЙН ҮЕД САХИН ХАМГААЛЪЯ**

**АРД ТҮМНИЙ ОЛОНХИЙН ЗАСАГЛАЛ НАМ**

00000003